

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын 16 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/108/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.Shinjlenmagadlahui.ezshaudit.mn Улаанбаатар хот 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр Утас: 70373089, 99023682 Цахим хаяг: Munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Утас: 99036806 Цахим хаяг: Batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 99377479 Цахим хаяг: Battsetsegs@audit.gov.mn Аудит гүйцэтгэсэн: Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит ХХК Утас: 99197346, 88114867 Цахим хаяг: Shinjlenmagadlahui.audit@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	
Аудитын гол асуудал	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	18
4.1 Ерөнхий зүйл.....	18
4.2 Материаллаг байдал	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	20
4.5.1 Завсрын аудитын талаар.....	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	21
5.1 Төлбөрийн акт	21
5.2 Албан шаардлага	21
5.3 Зөвлөмж	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗГ	Засгийн газар
ИТХ	иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 16 ДУГААР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Б.ДАВААНЯМ
ТАНАА

2025.02.25 № 108

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 16 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Дархан-Уул аймгийн Дархан сумын 16 дугаар сургуулийн 2024 оны үйл ажиллагааны орлого төлөвлөснөөс 701.1 мянган төгрөгөөр буюу 12.5 хувиар давж биелсэн нь түрээслэгч байгууллагын ашиглалтын зардал өссөнтэй холбоотой байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

4525020148

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр тус сургуулийн цалингийн зардал өнгөрсөн оны гүйцэтгэлээс 652,506.1 мянган төгрөгөөр буюу 34.7 хувиар өссөн байна.

Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 16 дугаар сургууль нь байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилт дэвшүүлэн төлөвлөж, хэрэгжилтийг 84.83 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

СТ-1А

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	619,910,560.98	638,220,641.64
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	456,072,276.06	433,051,207.12
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	456,072,276.06	433,051,207.12
3121	Төгрөг	456,072,276.06	433,051,207.12
31211	Төрийн сангийн харилцах	456,072,276.06	433,051,207.12
33	АВЛАГА	-	-
3351	Байгууллагаас авах авлага	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	163,838,284.92	205,169,434.52
351	Түүхий эд материал	787,290.00	586,470.00
3513	Эм боох материал	787,290.00	586,470.00
354	Хангамжийн материал	163,050,994.92	204,582,964.52
3541	Бичиг хэргийн материал	4,620,150.00	5,563,400.00
3542	Аж ахуйн материал	4,271,640.00	14,192,470.00
3547	Бусад хангамжийн материал	154,159,204.92	184,827,094.52
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	683,682,681.81	661,776,306.85
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	683,682,681.81	661,776,306.85
392	Биет хөрөнгө	679,282,681.65	658,476,306.93
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	564,900,556.39	650,399,133.75
39206	Хуримтлагдсан элэгдэл	(201,270,455.82)	(261,971,165.62)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	145,438,307.40	143,450,819.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(63,971,332.54)	(81,821,661.58)
39214	Бусад үндсэн хөрөнгө	267,456,584.00	267,456,584.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(80,236,975.32)	(106,982,633.76)
39217	Ном	46,965,997.54	47,945,230.74
393	Биет бус хөрөнгө	4,400,000.16	3,299,999.92
39301	Програм хангамж	6,624,300.00	6,624,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,224,299.84)	(3,324,300.08)
39303	Бусад биет бус хөрөнгө	32,426,767.00	32,426,767.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(32,426,767.00)	(32,426,767.00)
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,303,593,242.79	1,299,996,948.49
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,303,593,242.79	1,299,996,948.49
51	Засгийн газрын хувь оролцоо	1,303,593,242.79	1,299,996,948.49
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	635,249,372.36	635,249,372.36
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	635,249,372.36	635,249,372.36
512	Хуримтлагдсан үр дүн	666,638,590.02	663,042,295.72
5121	Өмнөх үеийн үр дүн	666,638,590.02	666,638,590.02
5122	Тайлант үеийн үр дүн	-	(3,596,294.30)
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,705,280.41	1,705,280.41
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,303,593,242.79	1,299,996,948.49


ХТ05430@9022889

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,217,858,413.74	3,524,501,526.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	277,033,608.74	108,772,026.50
120	Нийтлэг татварын бус орлого	277,033,608.74	108,772,026.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13,649,050.00	24,007,172.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,643,900.00	7,706,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,005,150.00	16,301,072.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	221,966,994.44	60,754,338.20
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	41,417,564.30	24,010,516.30
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,940,824,805.00	3,415,729,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,831,558,400.00	3,295,305,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,831,558,400.00	3,295,305,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	109,266,405.00	120,424,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	109,266,405.00	120,424,400.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,696,888,825.78	3,528,097,820.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,696,888,825.78	3,528,097,820.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,503,710,424.78	3,322,721,060.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,880,384,996.23	2,532,891,122.83
210101	Үндсэн цалин	1,291,576,823.65	1,632,593,941.42
210102	Нэмэгдэл	533,010,608.52	814,194,969.09
210104	Урамшуулал	55,797,564.06	86,102,212.32
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	242,092,152.46	322,534,382.99
210201	Тэтгэврийн даатгал	166,265,220.53	222,248,289.41
210202	Тэтгэмжийн даатгал	19,695,382.42	26,037,082.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,182,505.84	12,661,112.93
210204	Ажилгүйдлийн даатгал	3,711,252.33	12,271,082.27
210205	Эрүүл мэндийн даатгал	37,237,791.34	49,316,816.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	106,998,988.00	112,815,211.48
210301	Гэрэл, цахилгаан	17,176,380.39	20,166,029.12
210302	Түлш, халаалт	30,765,083.45	33,489,334.00
210303	Цэвэр, бохир ус	5,958,018.57	7,230,576.64
210304	Байрны түрээс	53,099,505.59	51,929,271.72
2104	Хангамж, бараа материалын зардал	3,485,604.12	3,209,760.00
210401	Бичиг хэрэг	1,746,650.00	3,209,760.00
210404	Ном, хэвлэл	401,958.12	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,336,996.00	-
2105	Нормативт зардал	797,700.00	201,620.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	131,000.00	201,620.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	666,700.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	49,527,515.00	24,752,690.88
210604	Урсгал засвар	49,527,515.00	24,752,690.88
2107	Томилолт, зочны зардал	-	660,000.00

210702	Дотоод албан томилолт	-	660,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,477,300.00	62,187,163.12
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,643,900.00	7,706,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	19,833,400.00	54,481,063.12
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	192,946,168.97	263,469,108.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	43,175,880.00	63,227,104.82
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	24,309,608.00	25,129,135.20
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	125,460,680.97	175,112,868.96
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	193,178,401.00	205,376,760.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	193,178,400.00	201,101,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	169,365,000.00	183,087,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	23,813,400.00	18,014,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1.00	4,275,260.52
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1.00	4,275,260.52
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	520,969,587.96	(3,596,294.30)



2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,954,473,855.00	3,439,736,672.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,649,050.00	24,007,172.00
120	Нийтлэг татварын бус орлого	13,649,050.00	24,007,172.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13,649,050.00	24,007,172.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,643,900.00	7,706,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,005,150.00	16,301,072.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,940,824,805.00	3,415,729,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,831,558,400.00	3,295,305,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,831,558,400.00	3,295,305,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	109,266,405.00	120,424,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	109,266,405.00	120,424,400.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,542,058,203.69	3,370,305,585.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,542,058,203.69	3,370,305,585.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,348,879,802.69	3,164,928,824.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,880,384,996.23	2,532,891,122.83
210101	Үндсэн цалин	1,291,576,823.65	1,632,593,941.42
210102	Нэмэгдэл	533,010,608.52	814,194,969.09
210104	Урамшуулал	55,797,564.06	86,102,212.32
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	242,092,152.46	322,534,382.99
210201	Тэтгэврийн даатгал	166,265,220.53	222,248,289.41
210202	Тэтгэмжийн даатгал	19,695,382.42	26,037,082.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,182,505.84	12,661,112.93
210204	Ажилгүйдлийн даатгал	3,711,252.33	12,271,082.27
210205	Эрүүл мэндийн даатгал	37,237,791.34	49,316,816.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	106,998,988.00	112,815,211.48
210301	Гэрэл, цахилгаан	17,176,380.39	20,166,029.12
210302	Түлш, халаалт	30,765,083.45	33,489,334.00
210303	Цэвэр, бохир ус	5,958,018.57	7,230,576.64
210304	Байрны түрээс	53,099,505.59	51,929,271.72
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,400,000.00	9,600,000.00
210604	Урсгал засвар	6,400,000.00	9,600,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,421,900.00	70,913,647.32
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,643,900.00	7,706,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	16,778,000.00	63,207,547.32
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	88,581,766.00	116,174,460.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	61,904,118.00	85,630,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,677,648.00	30,544,160.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	193,178,401.00	205,376,760.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	193,178,400.00	201,101,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	169,365,000.00	183,087,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	23,813,400.00	18,014,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн	1.00	4,275,260.52

	захирагчдад олгох татаас, санхүүжилт		
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1.00	4,275,260.52
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	412,415,651.31	69,431,086.86
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	73,089,000.00	92,452,155.80
	Дотоод эх үүсвэрээр	73,089,000.00	92,452,155.80
222001	Тоног төхөөрөмж	73,089,000.00	92,138,715.80
223001	Бусад хөрөнгө	-	313,440.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(73,089,000.00)	(92,452,155.80)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	339,326,651.31	(23,021,068.94)
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	456,072,276.06
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		433,051,207.12



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	635,249,372.36	2,419,318.81	151,962,333.02	789,631,024.19
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	714,038.40	714,038.40
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(714,038.40)	-	(714,038.40)
Тайлант үеийн үр дүн	-	-	513,962,218.60	513,962,218.60
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	635,249,372.36	1,705,280.41	666,638,590.02	1,303,593,242.79
Тайлант үеийн үр дүн	-	-	(3,596,294.30)	(3,596,294.30)
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	635,249,372.36	1,705,280.41	663,042,295.72	1,299,996,948.49



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,912,736,000.00	3,458,447,480.42	(454,288,519.58)	88.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,912,736,000.00	3,458,447,480.42	(454,288,519.58)	88.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,684,179,400.00	3,257,345,980.42	(426,833,419.58)	88.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,869,821,900.00	2,532,891,122.83	(336,930,777.17)	88.26
210101	Үндсэн цалин	1,969,688,900.00	1,632,593,941.42	(337,094,958.58)	82.89
210102	Нэмэгдэл	826,923,500.00	814,194,969.09	(12,728,530.91)	98.46
210104	Урамшуулал	73,209,500.00	86,102,212.32	12,892,712.32	117.61
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	358,727,600.00	322,534,382.99	(36,193,217.01)	89.91
210201	Тэтгэврийн даатгал	243,934,800.00	222,248,289.41	(21,686,510.59)	91.11
210202	Тэтгэмжийн даатгал	28,698,200.00	26,037,082.02	(2,661,117.98)	90.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,349,100.00	12,661,112.93	(1,687,987.07)	88.24
210204	Ажилгүйдлийн даатгал	14,349,100.00	12,271,082.27	(2,078,017.73)	85.52
210205	Эрүүл мэндийн даатгал	57,396,400.00	49,316,816.36	(8,079,583.64)	85.92
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	134,052,900.00	112,815,211.48	(21,237,688.52)	84.16
210301	Гэрэл, цахилгаан	22,728,500.00	20,166,029.12	(2,562,470.88)	88.73
210302	Түлш, халаалт	46,780,600.00	33,489,334.00	(13,291,266.00)	71.59
210303	Цэвэр, бохир ус	9,043,800.00	7,230,576.64	(1,813,223.36)	79.95
210304	Байрны түрээс	55,500,000.00	51,929,271.72	(3,570,728.28)	93.57
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,600,000.00	9,600,000.00	-	100
210604	Урсгал засвар	9,600,000.00	9,600,000.00	-	100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	87,979,300.00	80,000,163.12	(7,979,136.88)	90.93
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,706,100.00	7,706,100.00	-	100
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	80,273,200.00	72,294,063.12	(7,979,136.88)	90.06
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	223,997,700.00	199,505,100.00	(24,492,600.00)	89.07
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	190,740,100.00	166,247,500.00	(24,492,600.00)	87.16
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	33,257,600.00	33,257,600.00	-	100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	228,556,600.00	201,101,500.00	(27,455,100.00)	87.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	228,556,600.00	201,101,500.00	(27,455,100.00)	87.99
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	210,542,100.00	183,087,000.00	(27,455,100.00)	86.96

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,014,500.00	18,014,500.00	-	100
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,912,736,000.00	3,435,426,411.48	(477,309,588.52)	87.8
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,295,305,100.00	3,295,305,100.00	-	100
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,295,305,100.00	3,295,305,100.00	-	100
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	138,052,900.00	116,149,139.48	(21,903,760.52)	84.13
132001	Орон нутгийн төсвөөс	138,052,900.00	116,149,139.48	(21,903,760.52)	84.13
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	479,378,000.00	23,972,172.00	(455,405,828.00)	5
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,706,100.00	7,706,100.00	-	100
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,600,000.00	16,266,072.00	666,072.00	104.27
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	456,071,900.00	-	(456,071,900.00)	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	456,072,276.06	456,072,276.06	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	433,051,207.12	433,051,207.12	
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		100
3	Төсвийн байгууллага	1	1		100
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	97	96	1	98.97
6	Удирдах ажилтан	1	1		100
7	Гүйцэтгэх ажилтан	84	83	1	98.81
8	Үйлчлэх ажилтан	12	12		100
11	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	1,757.00	1,710.00	47	97.32
12	Төрийн өмчит ЕБС	3,912,736,000.00	3,458,447,480.42	(454,288,519.58)	88.39

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан байхгүй байна.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Дархан сумын 16 дугаар сургууль нь “Эрдэм оюуныг хүүхэд бүрд, Эерэг харилцааг хүн бүрд” гэх эрхэм зорилгын хүрээнд “Хүсэл зорилгоо тодорхойлж хэрэгжүүлдэг хүүхэд” гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Унших, уншсанаа ойлгох, ойлгосноо хэрэгжүүлэх үйлийг өөрийн түвшинд бүрэн эзэмшсэн хүүхэд
2. Шинжлэх ухаанч мэдлэг чадварт тэмүүлж, өөрийнхөө хөгжлийн дэмжлэг болгох

3. Эрүүл мэнд, бие бялдар, сэтгэл зүйгээ амжилттай суралцахуйд тохируулан жолоодох чадвартай хүүхэд

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

- Монгол улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан
- Монгол улсын засгийн газрын 25 дугаар тогтоол “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”-ыг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс,
- Монгол улсын засгийн газрын “Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай” 39 дүгээр тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс,
- Монгол улсын засгийн газрын 104 дүгээр тогтоол “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багш, ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журам”-ыг 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрөөс,
- Монгол улсын засгийн газрын “Тогтоолд хавсралт нэмэх, тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай” 84 дүгээр тогтоолыг 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрөөс
- Монгол улсын засгийн газрын 82 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам”-ыг 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрөөс,
- Монгол улсын засгийн газрын “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоолыг 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрөөс,
- Монгол улсын засгийн газрын “Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүрийг шинэчлэн батлах тухай” 53 дугаар тогтоол батлагдаж 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдрөөс тус тус мөрдөж эхэлсэн байна.

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл

үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 16 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцүүлэн бэлтгэсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан-Уул аймгийн Дархан сумын 16 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,596.3 мянган төгрөгөөр буюу 0.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	456,072.3	433,051.2	(23,021.1)
Бараа материал	163,838.3	205,169.4	41,331.1
Үндсэн хөрөнгө	683,682.7	661,776.3	(21,906.4)
Нийт хөрөнгө	1,303,593.2	1,299,996.9	(3,596.3)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,303,593.2	1,299,996.9	(3,596.3)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,303,593.2	1,299,996.9	(3,596.3)

Тайлант жилийн үйл ажиллагааны зардлын хэмнэлт 433,051.2 мянган төгрөгийг Засгийн газрын 2024 оны 53 дугаар тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”-ын 8.4-д “Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсан байна. Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 433,051.2 мянган төгрөг болж 23,021.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл оны эцэст 205,169.4 мянган төгрөг болж өссөн нь төсвийн хөрөнгөөр 90,202.6 мянган төгрөгийн барааг худалдан авч, 24,010.5 мянган төгрөгийн барааг Боловсролын газраас шилжүүлгээр тус тус бэлтгэсэн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 661,776.3 мянган төгрөг болж 21,906.4 мянган төгрөгөөр буурсан нь 400.0 мянган төгрөгийн хөрөнгийг хандиваар, 47,812.1 мянган төгрөгийн хөрөнгийг Боловсролын газраас шилжүүлгээр, 92,452.1 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, 54,561.3 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ тогтоон дахин үнэлж 12,542.2 төгрөгийн өртгөөр данс бүртгэлд дахин

тусгасан, Аймгийн засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 01-А/313 тоот захирамжаар 14,154.9 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,299,996.9 мянган төгрөг болж 3,596.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Дархан-Уул аймгийн Дархан сумын 16 дугаар сургуулийн 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,923,630.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 160,710.1 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 5,600.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөсөн байна.

Тайлант оны батлагдсан төсвийг оны сүүлд 366,723.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж санхүүжүүлж, Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 зорилтын хүрээнд 14 арга хэмжээг 3,295,305.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 138,052.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 23,306.1 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр, 456,071.9 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төсөвлөсөн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Дархан-Уул аймгийн Дархан сумын 16 дугаар сургуулийн нь гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,295,305.1 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 116,149.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлого 23,972.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,458,447.5 мянган төгрөг буюу 88.39 хувьтай байгаа нь цалинтай холбоотой зардлаас 373,124.0 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой зардлаас 21,237.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 7,979.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардлаас 24,492.6 мянган төгрөг, үдийн хоол хөтөлбөрөөс 27,455.1 мянган төгрөг, нийт 454,288.5 мянган төгрөгийг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	8,314.40	8,314.40	-	100.00
2	80233- Хүүхэд хамгаалал	8,589.80	8,427.60	(162.20)	98.11
3	80312- Сургалт семинар	5,738.90	5,624.60	(114.30)	98.00
4	81605- Эрүүл мэндийг дэмжих	8,331.60	5,355.00	(2,976.60)	64.27
5	81801- Үдийн цай хөтөлбөр	210,542.10	183,087.00	(27,455.10)	86.96
6	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	67,166.60	67,166.6	-	100.00
7	81823- Боловсролын багшийн сургалт	26,888.90	9,270.00	(17,618.90)	34.47
8	81834- Боловсролын стандарт сургалт	3,291,829.20	2,918,668.34	(373,160.9)	88.66
9	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	106,275.90	102,692.20	(3,583.70)	96.63
10	81848- Сурах бичгийн түрээс	7,706.10	7,706.10	-	100.00

11	81875- Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	17,699.60	9,720.50	(7,979.10)	54.92
12	83603- Дээд шатны төсвөөс хуваарилсан	10,000.00	10,000.00	-	100.00
13	80111- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	143,652.90	122,415.21	(21,237.69)	85.22
	Нийт дүн	3,912,736.00	3,458,447.55	(454,288.49)	88.39

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 16 дугаар сургууль нь ахмадын сан байгуулж, хөрөнгө мөнгө төвлөрүүлээгүй байна.

Төсвөөс 2024 онд зарцуулсан бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж болох 7,706.1 мянган төгрөг нь сурах бичгийн түрээсийн орлого бөгөөд тайлант онд Боловсролын ерөнхий газрын дансанд төвлөрүүлсэн байна.

Бараа ажил үйлчилгээний бусад зардалд нийт 166,282.5 мянган төгрөгийг зарцуулж төсвийн гүйцэтгэл 87.16 хувьтай байна. Дээрх зардалд Монгол улсын засгийн газрын “Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүрийг шинэчлэн батлах тухай” 53 дугаар тогтоолоор батлагдсан байр ашиглалтын үйлчилгээ, хүүхэд хамгаалал, эрүүл мэндийг дэмжих зардал, сургалт семинар, хүүхдэд ээлтэй сургалтын орчин бүрдүүлэх, багшийн хөгжлийг дэмжих, сургалтын байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зориулалт бэхий бараа үйлчилгээний бусад зардал багтаж байна.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 16 дугаар сургууль нь сургуулийн захирлын 2024 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн А/35 тоо тушаалаар 97 хүний орон тоо баталж, тайлант оны сүүлд 96 хүний орон тоотойгоор ажилласан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд тус байгууллага дээр улсын болон орон нутгийн төсөв, хандив тусламжаар аливаа төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл бичих

Тус байгууллага нь 2024 онд үдийн цай хөтөлбөрийн хүнсний материалын худалдан авалт болох 185,068.8 мянган төгрөгийн нээлттэй тендер шалгаруулалтыг 2024 оны 02-р сарын 15-ны өдөр зарлаж, шалгарсан “Зеретереза” ХХК 2024 оны 3-р сарын 15-ны өдөр гэрээ байгуулан ажилласан. Тайлант онд үдийн цай хөтөлбөрийн гүйцэтгэл 183,087.0 мянган төгрөг байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 16 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, санхүүгийн сахилга батыг дээшлүүлж, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит” ХХК-ийн аудитор Б.Хоролбат гүйцэтгэж, Анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер Л.Магсаржалам, гүйцэтгэх захирал С.Оргил нар дараагийн шатны чанарын хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 16 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Шинжлэн магадлахуй ЭЗШ” аудит ХХК-д 2025 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлан дахь нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлан дахь нийт зардал 2,696,888.8 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 26,968.9 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Дархан-Уул аймгийн Дархан сумын 16 дугаар сургууль нь ашиглалтын зардлын хэрэглээг хянаж ажилласан байна.

Энэ хуулийн хүрээнд гүйцэтгэлээр санхүүжүүлсэнтэй холбоотойгоор цалинтай холбоотой зардлаас 373,125.9 мянган төгрөг, үдийн хоол хөтөлбөрөөс 27,455.1 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 21,237.69 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардлаас 24,257.6 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгон ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д заасан тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг төсөв хугацаа хоцорч ирсний улмаас мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд гарсан алдаа, зөрчилтэй асуудал байхгүй.

Харин Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д " Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу "Ахмадын сан" байгуулж, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллах журам"-ын дагуу сангийн хөрөнгийг бүрдүүлж зарцуулан, гүйцэтгэлийг тайлагнаж, хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дархан-Уул аймгийн Дархан сумын 16 дугаар сургуулийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 115,391.9 мянган төгрөгийн зөрчил илэрсэн тул цаашид үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах 6 зөвлөмж өгсөн бөгөөд хэрэгжилтийг шалгахад 100.0 хувь хэрэгжсэн байна.

Хүснэгт 4 Зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	6	115,391.9	6	115,391.9	100
Нийт дүн	6	115,391.9	6	115,391.9	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Боловсролын ерөнхий газраас 2024 оны 12 дугаар сарын 12-ний өдөр баталсан 3,650,399.8 мянган төгрөгийн төсвийн хуваарийг 30-ны өдөр 118,683.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2024 оны 12 дугаар сарын 28-ны өдөр төрийн сангийн 100190115166 тоот дансанд төвлөрсөн тул харилцах дансны үлдэгдэл өсөж төсвийн гүйцэтгэл 88.39 хувьтай гарсан байна. Иймд төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудлыг дараагийн шатны аудитаар шалгаж, шийдэл гаргах нь зүйтэй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 111,967.6 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 92,452.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 864.6 мянган төгрөгийн төлбөрийн акт,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

18,650.8 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ. Үүнд:

- Санхүүгийн тайлангийн Мөнгөн гүйлгээний тайланд хөрөнгө худалдаж авсан 92,452.2 мянган төгрөгийг биет болон биет бус хөрөнгө худалдан авсан зардалд тусгаагүй нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам", санхүүгийн тайлангийн аудитын "Ангилал", "Нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул залруулав.

5.1 Төлбөрийн акт

1. Сургуулийн захирал Б.Давааням нь өөртөө тушаал гаргаж, 864.6 мянган төгрөгийн илүү цагийн хөлс авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.5 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.6.2 дахь заалт, 16 дугаар зүйлийн 16.5.9 дахь заалт, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй нь эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.3.1. Цалингийн зардлын данстай холбоотой асуудал

5.3.1.1 Илрүүлэлт:

Байгууллагын даргын 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/64 дугаар албан бичгийг үндэслэн ажилтан албан хаагчдад нэг удаагийн шагнал, урамшууллын 7,342.0 мянган төгрөгийг цалингийн зардлаас зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дэх заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх заалт, байгууллагын 2024 оны батлагдсан төсөвтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, цаашид дээрх алдааг давтан гаргахгүй байх.

5.3.2. Үндсэн хөрөнгийн зардлын данстай холбоотой асуудал

5.3.2.1 Илрүүлэлт:

Бараа үйлчилгээний бусад зардлаас 7,839.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн ба цахим дэлгүүрээс аваагүй хувь хүнээс авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Худалдан авах ажиллагааг Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасны дагуу цахим дэлгүүрээс худалдан авах

5.3.3. Цалингийн зардлын данстай холбоотой асуудал

5.3.3.1 Илрүүлэлт:

Өндөр насны тэтгэвэрт гарсан үйлчлэгч Л.Сувдаад ур чадвар, үр дүнгийн урамшуулал 1,147.5 төгрөгийн хөлс олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" 5.1.5-д "хариуцлагатай байх", Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-д "төрийн албан хаагч" гэж төрийн албан тушаалыг эрхэлж, эрх, үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг", Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 25-ний өдөр 07 тоот зөвлөмжийн 8 дугаар заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Тэтгэвэрт гарсан ажилтанд хөдөлмөрийн гэрээнд тусгаагүй нэмэгдэл урамшуулал олгохгүй байх, цаашид дээрх алдааг давтан гаргахгүй байх.

5.3.4. Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардалтай холбоотой асуудал

5.3.4.1 Илрүүлэлт:

Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр 4 дүгээр түвшинд үнэлэгдэж, ажилтнуудад 18,014.5 мянган төгрөг олгохдоо 2,055.8 төгрөгийн НДШ суутгаагүй, 266.2 төгрөг ХХОАТ дутуу суутгасан байна. Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.3-д "ажил олгогчоос даатгуулагчид мөнгөн хэлбэрээр олгосон хоол, унаа, түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт, орон сууцны ашиглалтын төлбөр, тэдгээртэй адилтгах бусад орлого, сар, улирал, жилийн ажлын үр дүнг харгалзан олгосон шагнал, урамшуулал", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д "Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна", 7.1.1-д "ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллын дүнгээс Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хувь хэмжээгээр шимтгэл тооцож, татвар суутгаж байх

Дээрх зөвлөмжөөс гадна тайлангийн 4.4.2 дахь хэсэгт дурдсан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5²-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн үндсэн хөрөнгийг мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгө оруулалт мөнгөн зардал хэсэгт тайлагнаагүй.	1	92,452.2			1	92,452.2	1	92,452.2				
Дүн	1	92,452.2			1	92,452.2	1	92,452.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		/мянган төгрөгөөр/				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Зардал хооронд гүйлгэн зарцуулсан	1	7,342.0					1	7,342.0				
Шийдвэргүй илүү цагийн хөлс авсан	1	864.6	1	864.6								
Цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй	1	7,839.3					1	7,839.3				
Өндөр настанд ур чадвар, үр дүнгийн урамшуулал олгосон	1	1,147.5					1	1,147.5				
Нэмэгдэл урамшууллаас НДШ, ХХОАТ суутгаагүй	1	2,322.0					1	2,322.0				
Дүн	5	19,515.4	1	864.6			4	18,650.8				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Ахмадын сан байгуулж, хөрөнгө мөнгө төвлөрүүлээгүй байна.	1	-	-	-	-	-	1	-
Дүн	1	-	-	-	-	-	1	-